



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/161


Есөнбулаг

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.9 дэх хэсэг, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 07 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Шинэ сэргэлт"-ийн бодлого, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 8.1.8 дахь заалт "Алтай сумыг эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй болгох" ажлын хүрээнд БНХАУ-ын Шинжан Уйгарын өөртөө Засах орны Хами аймгаас Алтай суманд 35кВт цахилгаан эрчим хүч холбох асуудлаар уулзалт хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүний шатахууны зардал 1,676,000 (нэг сая зургаан зуун далан зургаан мянга) төгрөгийг хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав), Санхүү төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2024 оны
01-дугаар сарын 02-ны өдрийн 161 дугаар
захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын утга	Туулах зам /км/	Машины тоо /ш/	зарцуулагдах шатахуун	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Шатахуун	1000	2	400	4190	1 676 000
Нийт дүн						1 676 000

__оОо__

